

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн: Г.Мөнхцэцэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Газрын төлбөрийн тухай хууль нь 1997 онд батлагдсан бөгөөд тодорхой хугацаанд зорилтоо бүрэн хангаж, газрын суурь үнэ, төлбөртэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн боловч газрын төлбөрийг зах зээлийн эрэлт нийлүүлэлт, инфляцын түвшинтэй уялдуулан тогтоох, улмаар газрын төлбөрийг эдийн засгийн хөшүүрэг болгон ашиглах, төлбөрийг тооцох үзүүлэлт, хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх, төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой асуудлуудыг бүрэн зохицуулахаар энэ хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар газрын төлбөр нь зах зээлийн үнэлгээнд тулгуурлан татварын суурийг өргөжүүлэх, татвар тэгш шударга, үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлж, газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлдэг болох, газрын төлбөр ногдуулах, төлбөр төлөх харилцаа ил тод, энгийн ойлгомжтой, хүнд сурталгүй болох нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.САРАНЧИМЭГ